

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны дүгээр
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор баталсан "Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал"-ын 4.5 дугаар зүйл, "Булган мээж" ОНӨХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/301 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Булган аймгийн Булган сумын төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг "Булган-Мээж" ОНӨХХК (Г.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 459, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 184 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ний өдрийн
.... дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Булган аймгийн Булган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөвт байгууллага	Эзлэхүүнээр халаалт		Төг/м³	3,900.0
		Хэмжүүрээр халаалт	хувьсах	Төг/ГЖ	68,938.0
			тогтмол	Төг/м³	497.0
		Хэрэгцээний халуун ус халаасан дулаан		Төг/м³	4,500.0

-oOo-

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ний өдрийн
.... дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА БОЛОН
АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Булган аймгийн Булган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	Эзлэхүүнээр халаалт		Төг/м³	1,900.0
		Хэмжүүрээр халаалт	хувьсах	Төг/ГЖ	32,606.0
			тогтмол	Төг/м³	235.0
		Хэрэгцээний халуун ус халаасан дулаан		Төг/м³	4,500.0
2	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “00” –ын өрөөний халаалт хамаарна)		Төг/м²	1,080.0	
3	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан		Төг/м³	3,500.0	

-oOo-